

**Аудитын код: САГ-2017/5/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа

Утас: 261663, 99117973 Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 262451, 93014814 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж

Утас: 261740, 99027789 Цахим хаяг: tserendorj@audit.gov.mn

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал..	<b>Error! Bookmark not defined.</b>
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	<b>Error! Bookmark not defined.</b>
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	<b>Error! Bookmark not defined.</b>
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.12	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1	«management zurchil1».....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2	«management zurchil2».....	<b>Error! Bookmark not defined.</b>
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл ....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... **Error! Bookmark not defined.**



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,  
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/249  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

## Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайханд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрөөс 1 дүгээр сарын 31-ний хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017 оны 1 дүгээр сарын 17-нд рийн аудитын байгууллагад 03/59 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрхэм зорилго нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын баталгааг дээшлүүлж, иргэдэд хүртээмжтэй, бүтээмжтэй, хариуцлагатай шүүхийн үйлчилгээг хүргэх явдал мөн.

Үндсэн хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь дараах үндсэн чиглэл, зорилттой байна. Үүнд:

1. Шүүгчийн хараат бус байдлыг хангаж, хамгаалах,
2. Шүүхийн бие даасан байдлын баталгааг нэмэгдүүлэх,
3. Хуульчдаас шүүгчийг шилж олох, мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох,
4. Шүүгчийн ёс зүй, хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэх,
5. Шүүхийн захиргааг удирдах.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, бусад хууль тогтоомжуудтай нийцсэн байна.

Дотоод аудитын алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу Ажлын алба болон шүүхүүдийн Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай зэрэг холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, эрсдлээс урдчилан сэргийлэх зорилго бүхий дотоод хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэж хангалттай хэмжээнд ажилладаг байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн "Acolous" програм хангамж ашиглажээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 эрсдэл өндөр, 1 эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-В-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 3 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлын дүнг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь илүү бодитой гэж үзэж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 3,847.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 76.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь илүү бодитой гэж үзсэнтэй холбоотой юм.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 6 чиглэлээр 10 эрсдэлтэй асуудалд 5 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 90.0 хувь буюу 9 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	6	2,657.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	6	2,657.9	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, ГАРГАСАН ШИЙДЭЛ

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

## 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 3,003.0 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгө ө	Гүйцэтгэ л	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,003.0	3,001.7	99.9	1.3
1	Урсгал зардал	3,003.0	3,001.7	99.9	1.3

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит					
1.	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
2.					
1.	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
3.					
2.	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр				
2.	Улсын төсвөөс санхүүжих				
1.					
2.	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.					
2.	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				
3.					

Төсөвт зардлын гүйцэтгэл 99.9 хувь байна..

## 2.10 Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

## 2.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийг 100 хувь биелүүлсэн байна.

## 2.12 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.**

### 3.1 Цалин УРАМШУУЛАЛ

#### Илрүүлэлт

Хангамж үйлчилгээний албанд ажилладаг нийт 20 хүнээс 19 хүнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Б/09 дугаар тушаалаар ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувиар олгохоор шийдвэрлэсэн байна. Ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг олгохдоо ажлын гүйцэтгэл, гаргасан амжилт зэргийг үнэлж дүгнэсэн баримт материал, хурлын тэмдэглэл байхгүй байна. Гацуурт дахь сургалтын баазад ажиллуулахаар 9 хүнд тус бүр 600.0 мянган төгрөгийн хөлс олгохоор гэрээг 2016 оны 4 дүгээр сарын 18-нд байгуулсан байна. Дээрх ажилтнуудын гэрээгээр ажиллуулах тушаал шийдвэр гараагүй, гэрээ дүгнэсэн материал байхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2-д "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан, эсвэл гоц авьяастай ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### Хариуцах ажилтан

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан  
Ахлах нягтлан бодогч Д.Очбаяр

#### Эрсдэл

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, үрэгдэх

#### Зөвлөмж

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

#### Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн байна.Цаашид анхаарч ажиллана.

### 3.2 Үндсэн хөрөнгө

#### Илрүүлэлт

1. МУ-ын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 6 тоот тогтоолоор Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2.2 тэрбум төгрөгийн конторын барилгыг Захиргааны хэргийн шүүхийн нэгдсэн байрны зориулалтаар ашиглахаар Шүүхийн ерөнхий зөвлөлд балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба 2016 оны 5 дугаар сарын 1-ны өдөр уг барилгыг балансдаа бүртгэж авсан байна. Гэтэл уг барилгад Захиргааны хэргийн шүүх үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө, өр төлбөр тухайн аж ахуй нэгж байгууллагад бодитой оршин байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. 224.7 сая төгрөгний үндсэн хөрөнгийг тушаал шийдвэргүйгээр орлогод авсан байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн байранд ажиллаж байгаа цайны газартай түрээсийн гэрээ байгуулаагүй, төлбөр тооцоо хийдэггүй байгаа нь Засгийн газрын 134 дүгээр тушаалаар баталсан Т өрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журмын 2-д "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3,4,5-д зааснаас бусад төрийн өөрийн өмчийн бүх төрлийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд

#### Зөвлөмж

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 134 дүгээр тушаалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах.

хамаарах, хөдлөх эд хөрөнгийг түрээслүүлж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Хариуцах ажилтан**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан  
Ахлах нягтлан бодогч Д.Очбаяр

**Эрсдэл**

Төрийн өмч хөрөнгийг зориулалт бусаар ашиглах, зарцуулах, дотоод хяналт хангалтгүй байх, орлого дутуу төвлөрүүлэх, Санхүүгийн тайлан үнэн, зөв, бодиттой илэрхийлээгүй байх, стандарт зөрчигдөх.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн байна.Цаашид анхаарч ажиллана.

### 3.3 ЦАЛИН УРАМШУУЛАЛ

#### Илрүүлэлт

Шүүхийн судалгаа мэдээлэл сургалтын хүрээлэн нь 5 референт, 6 судлаачийн орон тоотойгоор ажиллахаар батлагдсан боловч Гэрээгээр 2 судлаач, хөдөө ажиллах жолооч 1, Дүнжингарав худалдааны төвд шүүхийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх ажилтан 2-ийг авч ажиллуулсан. Гэрээт ажилтны цалинд нийт 17.0 сая төгрөг олгосон байна. Дээрх гэрээт ажилтныг цалинжуулсан, гэрээт ажилтнуудтай байгуулсан гэрээгээ дүгнээгүй байгаа нь МУЗГ-ын 2014 оны 147 дугаар тогтоолын 3.3-т "шинээр орон тоо нэмэгдүүлэхгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулж орон тоог бууруулах, сул чөлөөтэй орон тоонд томилгоо хийхгүй байх замаар цалингийн зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

#### Хариуцах ажилтан

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан  
Ахлах нягтлан бодогч Д.Очбаяр

#### Эрсдэл

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, үрэгдүүлэх

#### Зөвлөмж

Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

#### Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн байна.Цаашид анхаарч ажиллана.

### 3.4 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

#### Илрүүлэлт

#### Зөвлөмж

Тайлант онд Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 3,001.7 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвөөс 1.3 сая төгрөг хэмнэж ажилласан боловч унаа хоолны хөнгөлөлтийг 44.7 сая төгрөгөөр, үр дүнгийн урамшууллыг 1.0 сая төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 6.2 сая төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 2.7 сая төгрөгөөр, ном хэвлэл захиалгын зардлыг 6.2 сая төгрөгөөр, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 12.3 сая төгрөгөөр нийт 77.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Сангийн сайдын 2013 оны "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай" 73 дугаар тушаалаар батлагдсан журмын 8 дугаар зүйлийн 8.1-д "Төсвийн байгууллага нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахаас өөр бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

#### Хариуцах ажилтан

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан  
Ахлах нягтлан бодогч Д.Очбаяр

#### Эрсдэл

Төсвийн хөрөнгийг буруу төлөвлөх, зориулалтын бус зүйлд зарцуулах

Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай" журмыг хэрэгжүүлж ажиллах.

#### Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн байна.Цаашид анхаарч ажиллана.

### 3.5 БАРАА МАТЕРИАЛ

#### Илрүүлэлт

Тайлант онд бэлтгэсэн 9,8 сая төгрөгийн бичиг хэргийн болон эм урвалж, боох материалыг бараа материалын дансаар дамжуулаагүй шууд зардалд тусгасан, Баянтөхөм сургалтын төвд ашиглагдаж байгаа хүнсний материалын тайлан гаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4-н 21-д зааснаар худалдан авсан үед хийгдэх дансны бичилт Дт Хангамжийн материал Кт Мөнгөн хөрөнгө, /Дансны өглөг/ гэсэн бичилттэй нийцэхгүй байна.

#### Хариуцах ажилтан

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан  
Ахлах нягтлан бодогч Д.Очбаяр

#### Эрсдэл

Санхүүгийн тайлан үнэн, зөв, бодиттой гарахгүй, стандарт зөрчигдөх, НББ-д шат шатны хяналт хэрэгжүүлдэггүй байх, бараа материал санхүүгийн тайланд бүрэн тусгагдаагүй байх.

#### Зөвлөмж

Сангийн сайдын тушаалыг хэрэгжүүлж ажиллах.

#### Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн байна.Цаашид анхаарч ажиллана.

### 3.6 ТЭЭВЭР, ШАТАХҮҮН

#### Илрүүлэлт

#### Зөвлөмж

1. Жолоочийн шатахууны тооцооны хуудсыг маягтын дагуу бүрэн хөтөлж баталгаажуулдаггүй.

2. Жолоочийн тооцооны хуудсыг үндэслэн шатахууны тайланг гаргадаггүй, жолооч нарын шатахууны үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулдаггүй.

3. Хувь хүмүүсийн машинд 3.5 тонн буюу 5.4 сая төгрөгийн шатхуун олгоод замын хуудсаар авч тооцоо бодоогүй.

4. Зарим авто машины спидометрийн заалт оны эхний заалтаас буурсан зэрэг алдаа зөрчил байна. Энэ нь МУ-ийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

#### **Хариуцах ажилтан**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан  
Ахлах нягтлан бодогч Д.Очбаяр

#### **Эрсдэл**

Санхүүгийн тайлан үнэн, зөв, бодиттой бодитой илэрхийлэгдээгүй байх.

#### **Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн байна. Цаашид анхаарч ажиллана.

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>168,982,767.29</b>	<b>152,915,759.48</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>38,785,379.85</b>	<b>7,716,856.01</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	29,690.60	
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	38,755,689.25	5,731,922.01
335	Бусад авлага	-	1,984,934.00
3351	Байгууллагаас авах авлага		1,984,934.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>130,197,387.44</b>	<b>145,198,903.47</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>130,197,387.44</b>	<b>145,198,903.47</b>
35410	Бичиг хэргийн материал	12,914,861.44	10,508,110.52
35420	Аж ахуйн материал	62,928,526.00	93,679,592.95
35430	Сэлбэг хэрэгсэл	23,965,000.00	23,707,200.00
35440	Түлш, шатах тослох материал	30,389,000.00	17,304,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,007,879,040.24</b>	<b>9,076,881,026.07</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7,007,879,040.24</b>	<b>9,076,881,026.07</b>
391	Газар		
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>6,826,359,944.33</b>	<b>8,939,050,065.17</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,029,887,938.00	7,061,196,006.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(155,237,211.10)	(343,670,346.91)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,194,950,100.00	1,183,427,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(245,456,012.26)	(453,971,321.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,070,815,795.92	1,443,179,448.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(309,112,626.54)	(580,207,720.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	588,470,891.32	606,617,009.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	(137,499,861.21)	(187,373,532.07)
39209	Зам, гүүрийн байгууламж	85,733,800.00	85,733,800.00
39210	Хуримтлагдсан элэгдэл		(5,715,586.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	110,655,880.00	110,305,880.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(26,227,519.92)	(42,831,823.64)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	557,018,118.00	
39217	Ном	62,360,652.12	62,360,652.12
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>181,519,095.91</b>	<b>137,830,960.90</b>
39301	Програм хангамж	187,223,000.00	193,060,390.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,284,104.13)	(57,992,895.82)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,295,200.00	11,295,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(714,999.96)	(8,531,733.28)
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,176,861,807.53</b>	<b>9,229,796,785.55</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>29,690.60</b>	<b>-</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>29,690.60</b>	<b>-</b>
413	Өглөг	29,690.60	-
4136	Бусад өглөг	29,690.60	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	29,690.60	
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,176,832,116.93</b>	<b>9,229,796,785.55</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,176,832,116.93</b>	<b>9,229,796,785.55</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	759,010,324.95	759,010,324.95
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,387,119,909.89</b>	<b>8,440,084,578.51</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	6,387,119,909.89	6,387,119,909.89
51220	Тайлант үеийн үр дүн		2,052,964,668.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	30,701,882.09	30,701,882.09
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,176,861,807.53</b>	<b>9,229,796,785.55</b>

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,238,229,395.70</b>	<b>6,009,995,079.80</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>740,247,855.70</b>	<b>3,008,315,063.80</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	740,247,855.70	3,008,315,063.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	740,247,855.70	3,008,315,063.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,103,760.00	
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	739,144,095.70	3,008,315,063.80
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>3,497,981,540.00</b>	<b>3,001,680,016.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,497,981,540.00	3,001,680,016.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,497,981,540.00	3,001,680,016.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,525,032,764.11</b>	<b>3,847,194,108.16</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,525,032,764.11</b>	<b>3,847,194,108.16</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,241,980,352.12	3,766,635,401.49
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,144,008,314.63	1,987,410,135.73
210101	Үндсэн цалин	1,773,186,000.85	1,590,166,411.54
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	262,061,000.00	208,582,479.00
210104	Урамшуулал	108,761,313.78	188,661,245.19
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	233,583,700.00	220,741,883.78
210201	Тэтгэврийн даатгал	150,311,593.24	140,208,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,853,668.39	16,106,757.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,283,596.72	20,133,446.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,247,908.98	4,026,689.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,886,932.67	40,266,891.78
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	160,870,250.00	157,309,758.00
210301	Гэрэл, цахилгаан	92,430,430.33	103,589,759.00
210302	Түлш, халаалт		2,860,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,024,669.67	2,509,629.00
210304	Байрны түрээс	64,415,150.00	48,350,370.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	215,270,311.96	248,539,773.83
210401	Бичиг хэрэг	43,122,028.56	48,969,970.92
210402	Тээвэр, шатахуун	81,265,000.00	91,519,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,351,791.39	44,305,194.86
210404	Ном, хэвлэл	8,044,600.00	6,255,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,133,760.00	511,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,353,132.01	37,749,003.05
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		19,229,205.00
2105	<b>Нормативт зардал</b>	-	55,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		55,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	44,518,621.41	63,609,276.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,987,700.00	368,800.00

210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	42,530,921.41	63,240,476.00
2107	Томилолт, зочны зардал	63,249,729.00	56,307,398.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	51,175,740.00	43,933,617.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	12,073,989.00	12,373,781.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,493,071.00	67,222,467.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,411,677.00	45,601,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	12,821,076.00	14,169,538.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		2,313,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,661,000.00	228,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,871,950.00	3,982,261.00
210807	Газрын төлбөр	1,727,368.00	927,368.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	314,986,354.12	965,439,709.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,392,500.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	84,895,482.00	72,153,391.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	158,698,372.12	893,286,318.15
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	283,052,411.99	80,558,706.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,689,844.00	80,212,922.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,104,493.00	60,804,182.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		19,408,740.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс мэдлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,585,351.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	212,362,567.99	345,784.67
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	212,362,567.99	345,784.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	713,196,631.59	2,162,800,971.64
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	68,400,000.00	109,836,302.82
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	68,400,000.00	109,836,302.82
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(68,400,000.00)	(109,836,302.82)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	644,796,631.59	2,052,964,668.82

## АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,523,286,852.60</b>	<b>3,089,020,208.60</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,133,450.60</b>	<b>48,736,180.60</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,133,450.60	48,736,180.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,103,760.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,103,760.00	
120009	Бусад орлого	29,690.60	48,736,180.60
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,522,153,402.00</b>	<b>3,040,284,028.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,497,981,540.00</b>	<b>3,001,680,016.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,497,981,540.00	3,001,680,016.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>24,171,862.00</b>	<b>38,604,012.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	24,171,862.00	38,604,012.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,400,449,868.60</b>	<b>3,011,610,765.60</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,400,449,868.60</b>	<b>3,011,610,765.60</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,093,195,904.01</b>	<b>2,892,448,046.93</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,188,474,834.21</b>	<b>1,959,729,481.47</b>
210101	Үндсэн цалин	1,817,779,036.43	1,562,485,757.28
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	262,061,000.00	208,582,479.00
210104	Урамшуулал	108,634,797.78	188,661,245.19
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>233,583,700.00</b>	<b>219,376,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	170,423,439.58	139,603,492.90
210202	Тэтгэмжийн даатгал	12,631,952.95	15,954,694.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,790,127.05	20,038,783.98
210204	Ажилгүйдлийн даатгал	3,157,926.29	3,988,631.45
210205	Эрүүл мэндийн даатгал	31,580,254.13	39,791,096.86
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>160,870,250.00</b>	<b>159,278,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	92,430,430.33	105,389,001.00
210302	Түлш, халаалт		2,860,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,024,669.67	2,509,629.00
210304	Байрны түрээс	64,415,150.00	48,519,370.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>229,014,972.39</b>	<b>214,629,486.86</b>
210401	Бичиг хэрэг	45,715,790.00	42,190,169.00
210402	Тээвэр, шагахуун	92,107,000.00	78,584,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,341,191.39	44,310,886.86
210404	Ном, хэвлэл	19,298,050.00	6,255,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,133,760.00	481,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,419,181.00	42,807,031.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>880,000.00</b>	<b>1,499,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	880,000.00	1,499,700.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,635,838.00</b>	<b>27,772,725.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга	99,000.00	1,044,050.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	46,480,027.41	65,600,476.00
2107	<b>Томилдолт, зочны зардал</b>	<b>63,249,729.00</b>	<b>56,307,398.00</b>
210701	Гадаад албан томилдолт		

210702	Дотоод албан томилолт	51,175,740.00	43,933,617.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	12,073,989.00	12,373,781.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,493,071.00	115,056,638.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,411,677.00	93,435,471.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	12,821,076.00	14,169,538.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		2,313,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,661,000.00	228,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,871,950.00	3,982,261.00
210807	Газрын төлбөр	1,727,368.00	927,368.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,414,482.00	72,153,391.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,519,000.00	
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	84,895,482.00	72,153,391.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>307,253,964.59</b>	<b>119,162,718.67</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>94,861,706.00</b>	<b>118,816,934.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	24,171,862.00	38,604,012.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		60,804,182.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,104,493.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		19,408,740.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,585,351.00	
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>212,392,258.59</b>	<b>345,784.67</b>
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	212,392,258.59	345,784.67
213304	Хөрөнгийн		
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>122,836,984.00</b>	<b>77,409,443.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>122,836,984.00</b>	<b>77,409,443.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>122,836,984.00</b>	<b>77,409,443.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	122,836,984.00	77,409,443.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	122,836,984.00	77,409,443.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(122,836,984.00)</b>	<b>(77,409,443.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧӨЛГЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Хуульчлалт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,010,324.95	30,701,882.09	5,818,079,862.63		6,607,792,069.67
C02	Нягтлан болох бүртгэлийн боллогын өөрчлөлт			-75,756,584.33		-75,756,584.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	759,010,324.95	30,701,882.09	5,742,323,278.30	0.00	6,532,035,485.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			644,796,631.59		644,796,631.59
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,010,324.95	30,701,882.09	6,387,119,909.89	0.00	7,176,832,116.93
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,010,324.95	30,701,882.09	6,387,119,909.89	0.00	7,176,832,116.93
D02	Нягтлан болох бүртгэлийн боллогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	759,010,324.95	30,701,882.09	6,387,119,909.89	0.00	7,176,832,116.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Тайлант үеийн үр дүн			2,052,964,668.62		2,052,964,668.62
D08	Тайлант үеийн үр дүн			8,440,084,578.51	0.00	9,229,796,785.55
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,010,324.95	30,701,882.09	8,440,084,578.51	0.00	9,229,796,785.55

## АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайланг оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,002,983,800.00	3,001,334,231.33	270,090.67	
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,002,983,800.00	3,001,334,231.33	270,090.67	
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,921,391,400.00	2,921,121,309.33	270,090.67	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,958,959,000.00	1,958,827,472.47	131,527.53	3.25
210101	Үндсэн цалин	1,607,482,200.00	1,561,583,748.28	45,898,451.72	0.97
210102	Нэмэгдэл				
210103	Унаа хоолны хөнгөлөлт	163,833,600.00	208,582,479.00	(44,748,879.00)	1.27
210104	Урамшуулал	187,643,200.00	188,661,245.19	(1,018,045.19)	1.01
210105	Гэрээт ажлын хөлс				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	219,376,700.00	219,376,700.00	-	5.00
210201	Тэтгэврийн даатгал	139,603,492.90	139,603,492.90	-	1.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,954,694.81	15,954,694.81	-	1.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,038,783.98	20,038,783.98	-	1.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,988,631.45	3,988,631.45	-	1.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,791,096.86	39,791,096.86	-	1.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	159,278,000.00	159,278,000.00	-	3.76
210301	Гэрэл, цахилгаан	99,181,000.00	105,389,001.00	(6,208,001.00)	1.06
210302	Тулш, халаалт	3,000,000.00	2,860,000.00	140,000.00	0.95
210303	Цэвэр, бохир ус	2,978,000.00	2,509,629.00	468,371.00	0.84
210304	Байрны түрээс	54,119,000.00	48,519,370.00	5,599,630.00	0.90
2104	Хангамж, бараа материалын зардал	214,629,500.00	214,629,486.86	13.14	4.56
210401	Бичиг хэрэг	44,342,500.00	42,190,169.00	2,152,331.00	0.95
210402	Тээвэр, шагааруун	84,820,300.00	78,584,800.00	6,235,500.00	0.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,582,500.00	44,310,886.86	(2,728,386.86)	1.07
210404	Ном, хэвлэл		6,255,600.00	(6,255,600.00)	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, арнугтал	772,600.00	481,000.00	291,600.00	0.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,111,600.00	42,807,031.00	304,569.00	0.99
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,499,700.00	300.00	1.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл				
210502	Хоол, хунс				
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,499,700.00	300.00	1.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	164,190,300.00	164,189,304.00	996.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,912,200.00	41,810,145.00	(897,945.00)	1.02
210602	Тавилга	15,648,000.00	15,647,950.00	50.00	1.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл				
210604	Урсгал засвар	107,630,100.00	106,731,209.00	898,891.00	0.99
2107	Томилголт, зочны зардал	56,312,900.00	56,307,398.00	5,502.00	0.78
210701	Гадаад албан томилголт				
210702	Дотоод албан томилголт	56,312,900.00	43,933,617.00	12,379,283.00	0.78
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		12,373,781.00	(12,373,781.00)	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,991,100.00	74,859,857.00	131,243.00	1.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,604,100.00	45,601,300.00	2,800.00	1.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох				
210803	Даатгалын үйлчилгээ	14,169,600.00	14,169,538.00	62.00	1.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,321,400.00	2,313,400.00	8,000.00	1.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	237,000.00	228,600.00	8,400.00	0.96
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,659,000.00	11,619,651.00	39,349.00	1.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	927,368.00	72,632.00	0.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,153,900.00	72,153,391.00	509.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал				
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	72,153,900.00	72,153,391.00	509.00	
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	81,592,400.00	80,212,922.00		
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	81,592,400.00	80,212,922.00		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	62,183,600.00	60,804,182.00		

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,408,800.00	19,408,740.00		
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,002,983,800.00</b>	<b>3,001,334,231.33</b>	-	-
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,002,983,800.00</b>	<b>3,001,334,231.33</b>	-	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,002,983,800.00	3,001,334,231.33		
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>110.00</b>	<b>106.00</b>	-	-
620001	Удирдах ажилтан	6.00	6.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	60.00	48.00		
620003	Үйлчлэх ажилтан	44.00	34.00		
620004	Гэрээт ажилтан		18.00		